



БИЗКОН АУДИТ КОМПАНИЙН ХӨВСГӨЛ АЙМАГ
ДАХЬ САЛБАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/59/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
Мөрөн сум
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Бизкон аудит ХХК-ийн

Ахлах аудитор Ч.Мөнхбаяр

Утас: 99996784 Цахим хаяг: mm.bayar0711@gmail.com

Аудитор: Л.Пунсал-орлом

Утас: 88908680 Цахим хаяг: punsa73@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага.....	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.21 № 01/87
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИХ-УУЛ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ТАЙВАНЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	80,468,637.97	67,721,080.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	1,303,001.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,303,001.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,165,636.97	67,721,080.16
351	Түүхий эд материал	1,689,232.00	1,596,710.00
35130	Эм боох материал	1,689,232.00	1,596,710.00
354	Хангамжийн материал	77,476,404.97	66,124,370.16
35410	Бичиг хэргийн материал	325,500.00	488,000.00
35420	Аж ахуйн материал	2,995,480.00	3,091,080.00
35440	Түлш, шатах тослох материал	900,000.00	1,450,000.00
35460	Хүнсний материал	5,647,945.00	3,399,585.00
35470	Бусад хангамжийн материал	67,607,479.97	57,695,705.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	96,119,968.79	1,375,360,519.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	96,119,968.79	1,375,360,519.36
392	Биет хөрөнгө	84,521,968.79	1,363,487,519.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	28,984,330.00	1,327,188,049.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,703,576.24	-25,156,570.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,507,980.00	54,426,578.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,777,287.03	-18,148,476.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,883,230.54	28,230,951.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,209,492.14	-11,992,773.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,449,308.66	24,493,435.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-29,044,216.00	-19,244,865.22
39217	Ном	3,431,691.00	3,691,191.00
393	Биет бус хөрөнгө	11,598,000.00	11,873,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,598,000.00	11,598,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	176,588,606.76	1,443,081,599.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	176,588,606.76	1,443,081,599.52
51	Засгийн газрын хувь оролцоо	176,588,606.76	1,443,081,599.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71,342,040.30	71,342,040.30
51101	Өмч: - төрийн	71,342,040.30	71,342,040.30
512	Хуримтлагдсан үр дүн	79,325,858.22	1,349,831,336.98
51210	Өмнөх үеийн үр дүн	79,325,858.22	83,338,344.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,266,492,992.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,920,708.24	21,908,222.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	176,588,606.76	1,443,081,599.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	467,534,699.95	1,771,547,432.43
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,904,799.95	1,307,117,332.43
120	Нийтлэг татварын бус орлого	64,904,799.95	1,307,117,332.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,422,500.00	76,351,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	365,207,400.00	388,078,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	423,500.00	261,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	261,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	423,500.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,999,000.00	76,089,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,999,000.00	76,089,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	399,874,399.62	502,962,638.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,874,399.62	502,962,638.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	354,760,650.62	491,410,851.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,470,187.00	305,390,892.00
210101	Үндсэн цалин	186,494,540.00	187,654,131.00
210102	Нэмэгдэл	29,196,175.00	97,910,312.00
210104	Урамшуулал	20,779,472.00	19,826,449.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,571,600.00	39,440,708.31
210201	Тэтгэврийн даатгал	18,420,600.00	27,233,642.31
210202	Тэтгэмжийн даатгал	1,787,600.00	3,053,910.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,430,400.00	2,443,127.00
210204	Ажилгүйдлийн даатгал	357,800.00	602,212.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,575,200.00	6,107,817.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,839,679.00	72,165,093.00
210301	Гэрэл, цахилгаан	811,847.00	2,319,538.00
210302	Түлш, халаалт	33,011,328.00	69,566,784.00
210303	Цэвэр, бохир ус	16,504.00	278,771.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,638,991.53	15,377,174.81
210401	Бичиг хэрэг	605,900.00	311,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	960,000.00	161,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	242,000.00	261,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,640,320.00	1,431,100.00
210408	Бараа материал акталсны зардал	9,690,771.53	11,711,474.81
2105	Нормативт зардал	21,341,438.00	16,444,182.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,910,768.00	778,022.00
210502	Хоол, хүнс	19,430,670.00	15,666,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135,700.00	2,272,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	135,700.00	00.00

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	00.00	2,272,700.00
2107	Томилолт, зочны зардал	556,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	556,600.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	741,300.00	1,087,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	441,300.00	547,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,465,155.09	39,232,981.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	776,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,416,850.00	4,662,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,248,305.09	33,794,281.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,113,749.00	11,551,787.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	360,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,890,928.00	10,450,080.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,890,928.00	10,450,080.69
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,862,821.00	1,101,707.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,439,321.00	1,101,707.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	67,660,300.33	1,268,584,793.54
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,091,800.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,091,800.78
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,091,800.78
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	67,660,300.33	1,266,492,992.76

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн / төгрөгөөр /
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,342,040.30	25,920,708.24	11,665,557.89	108,928,306.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,342,040.30	25,920,708.24	11,665,557.89	108,928,306.43
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,295,290.94	21,295,290.94
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,342,040.30	25,920,708.24	79,325,858.22	176,588,606.76
D01	2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	71,342,040.30	25,920,708.24	79,325,858.22	176,588,606.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	4,012,486.00	4,012,486.00

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,342,040.30	25,920,708.24	83,338,344.22	180,601,092.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-4,012,486.00	00.00	-4,012,486.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,266,492,992.76	1,266,492,992.76
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,342,040.30	21,908,222.24	1,349,831,336.98	1,443,081,599.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	402,629,900.00	464,430,100.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	402,629,900.00	464,430,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	365,207,400.00	388,078,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	423,500.00	261,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	261,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	423,500.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,999,000.00	76,089,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,999,000.00	76,089,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	401,310,000.00	456,298,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,310,000.00	456,298,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,196,251.00	444,746,812.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,773,188.00	304,249,350.00
210101	Үндсэн цалин	187,797,541.00	187,654,131.00
210102	Нэмэгдэл	29,196,175.00	97,910,314.00
210104	Урамшуулал	20,779,472.00	18,684,905.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,571,600.00	39,279,249.31
210201	Тэтгэврийн даатгал	18,420,600.00	27,291,297.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,787,600.00	2,997,909.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,430,400.00	2,398,286.31
210204	Ажилгүйдлийн даатгал	357,800.00	596,036.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,575,200.00	5,995,721.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,559,679.00	72,715,093.00
210301	Гэрэл, цахилгаан	811,847.00	2,319,538.00
210302	Түлш, халаалт	32,731,328.00	70,116,784.00
210303	Цэвэр, бохир ус	16,504.00	278,771.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,813,084.00	4,568,400.00

/Төгрөгөөр/

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	571,400.00	311,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	960,000.00	161,400.00
210404	Ном, хэвлэл	267,900.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,800,000.00	261,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,713,784.00	2,333,800.00
2105	Нормативт зардал	31,543,900.00	15,647,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,600,000.00	563,300.00
210502	Хоол, хүнс	16,660,300.00	13,417,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,283,600.00	1,665,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,980,100.00	2,272,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,780,100.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	2,272,700.00
2107	Томилот, зочны зардал	556,600.00	00.00
210702	Дотоод албан томилот	556,600.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	741,300.00	1,087,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	441,300.00	547,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,656,800.00	4,927,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	776,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,856,800.00	4,151,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,113,749.00	11,551,787.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	360,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,314,428.00	10,450,080.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,314,428.00	10,450,080.69
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,439,321.00	1,101,707.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,439,321.00	1,101,707.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,319,900.00</u>	<u>8,131,500.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,319,900.00	8,131,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,319,900.00	8,131,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,319,900.00	8,131,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,319,900.00	8,131,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,319,900.00</u>	<u>-8,131,500.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	00.00	00.00

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	464,168,300.00	452,616,512.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	464,168,300.00	452,616,512.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,168,300.00	452,616,512.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	304,992,800.00	304,249,350.00
210101	Үндсэн цалин	187,535,700.00	187,654,131.00
210102	Нэмэгдэл	102,399,500.00	97,910,314.00
210104	Урамшуулал	15,057,600.00	18,684,905.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,174,100.00	39,279,249.31
210201	Тэтгэврийн даатгал	28,974,300.00	27,291,297.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,050,000.00	2,997,909.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,440,000.00	2,398,286.31
210204	Ажилгүйдлийн даатгал	610,000.00	596,036.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,099,800.00	5,995,721.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,816,800.00	72,715,093.00
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,319,538.00
210302	Түлш, халаалт	70,116,800.00	70,116,784.00
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	278,771.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,566,100.00	4,566,100.00
210401	Бичиг хэрэг	311,400.00	311,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	161,400.00	161,400.00
210404	Ном, хэвлэл	259,500.00	259,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,333,800.00	2,333,800.00
2105	Нормативт зардал	25,310,700.00	17,519,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	563,300.00	563,300.00
210502	Хоол, хүнс	21,209,500.00	13,417,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,537,900.00	3,537,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,272,700.00	8,272,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	2,272,700.00	2,272,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,105,200.00	1,087,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	565,200.00	547,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4929900.00	4927900.00

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	778,400.00	776,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,151,500.00	4,151,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	464,168,300.00	452,616,512.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	388,078,800.00	377,628,719.31
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	388,078,800.00	377,628,719.31
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	76,089,500.00	74,987,793.00
132001	Орон нутгийн төсвөөс	76,089,500.00	74,987,793.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
		/ төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	261,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	261,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	261,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	261,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	261,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	261,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261,800.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц

бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан тогилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, зардал, төрийн өмчтэй холбостой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн гэрээт аудитор Л.Пунсал-Орлом, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулдаг Их-Уул сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотосд хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллага нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны А/23 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Тайлант онд 5 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтын ажлын тайлан бичсэн боловч хангалтгүй байна.

Дотосд аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 399.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,266.5 сая төгрөгөөр буюу 817.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	00
Авлага	1.3	00	-1.3
Урьдчилгаа	00	00	00
Бараа материал	79.2	67.7	-11.5
Үндсэн хөрөнгө	96.1	1,375.4	1,279.3
Нийт хөрөнгө	176.6	1,443.1	1,266.5
Өр төлбөр	00	00	00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	176.6	1,443.1	1,266.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	176.6	1,443.1	1,266.5

Тайлант онд шинээр Хүүхдийн цэцэрлэгийн барилга ашиглалтанд орж 1,085.2 сая төгрөгийн барилга, 91.4 сая төгрөгийн гадна зам талбай, 125.4 сая төгрөгийн цахилгаан дамжуулах агаарын шугам болон дэд станц, БШУЯ-аас үнэ төлбөргүйгээр 5 нэр төрлийн 0.9 сая төгрөгийн тавилга, эд хогшил, элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 1 нэр төрлийн 0.3 сая төгрөгийн өртөгтэй програм хангамжийг дахин үнэлж орлого авсан, төсвийн хөрөнгөөр 10 нэр төрлийн 8.1 сая төгрөгийн хөрөнгө, нийт 1,315.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Мөн 2 нэр төрлийн 3.8 сая төгрөгийн барилга байгууламж, 17 нэр төрлийн 1.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, 12 нэр төрлийн 3.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 24 нэр төрлийн 10.8 сая төгрөгийн бусад хөрөнгө, 0.3 сая төгрөгийн програм хангамж, нийт 20.3 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын тушаал, шийдвэрийг үндэслэн акталж устгасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 560.7 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 22.5 сая төгрөгөөр бууруулж 538.2 сая төгрөгөөр 2021 оны төсвийг баталсан байна. Тус байгууллагын төсөвт Их-Уул сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 3 тоот тогтоолоор 39.0 сая төгрөгөөр төсвийг хасах зохицуулалт, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар 35.0 сая төгрөгийн төсвийг хасах зохицуулалт, нийт 74.0 сая төгрөгөөр төсвийг хасах зохицуулалтыг хийж, санхүүжүүлэх эх үүсвэрийг 464.2 сая төгрөг болгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 4 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 464.2 сая төгрөгийн төсөв баталсан ба 388.1 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 76.1 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд улсын төсвөөс 377.6 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 75.0 сая төгрөг, нийт 452.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 452.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 11.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 452.6 сая төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 95.4 хувийн, нормативт зардал 69.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/ /сая төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71801	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	464.2	452.6	11.6	97.5
80109	ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардал	76.1	75.0	1.1	98.6
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	21.2	13.4	7.8	63.3
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	226.8	225.9	0.9	99.6
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	140.1	138.3	1.8	98.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 1 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0.3 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж дээд шатны эрх бүхий байгууллагын шийдвэрээр хог хаягдалзайлуулах, хортон мэрэгчдийг устгах зардалд 0.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу цахим засаглал үндэсний хөтөлбөрийн хүрээнд биет болон биет бус хөрөнгийг бүртгэлд тусгасан эсэх, зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа эсэх асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар төлөвлөгөөнд тусгасны дагуу шалгахад асуудалтай зүйл илэрсэнгүй.

Тайлант оны дундуур буцааж татсан санхүүжилтийн дүн 24.0 сая төгрөгийг орлого бууруулж бүртгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Тус байгууллагын тайлант оны гүйцэтгэлийг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй хангамж, бараа материалын зардлыг 33.3 хувь буюу 11.2 сая төгрөгөөр, нормативт зардлыг 49.5 хувь буюу 15.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 37.2 хувь буюу 2.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн ч нийт зардлын дүнгээр 24.7 хувь буюу 94.6 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Гэвч тайлант онд батлагдсан төсвийг 2 удаа 74.0 сая төгрөгөөр хасах зохицуулалт хийсэн, жилийн эцсээр 11.6 сая төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан. Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулах мэдээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Шилэн дансанд байршуулах мэдээ

№	Мэдээ байршуулах хугацаа	Мэдээний тоо			
		Мэдээлбэл зохих нийт мэдээ	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жилээр гаргах мэдээ	11	9	0	2
2	Хагас жилээр гаргах мэдээ	4	4	0	0
3	Улирал бүр гаргах мэдээ	4	4	0	0
4	Сар бүр гаргах мэдээ	36	36	0	0
5	Тухай бүрт гаргах мэдээ	96	95	1	0
НИЙТ ДҮН:		151	148	1	2

Шилэн дансыг шалгахад тайлант онд мэдээлэх 151 мэдээнээс хуулийн хугацаа болоогүй 2 мэдээ, хугацаандаа мэдээлсэн 147 мэдээ, хугацаа хоцорч мэдээлсэн 1 мэдээлэл байна. Үүнд: Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд 1 мэдээ хугацаа хоцорч байршуулсан нь Шилэн дансны тухай

хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 17.5 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 71.3 сая төгрөг байгаа ба 53.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх ноцтой асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 0.004 сая төгрөгийн алдааг залруулж, 11.2 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тайлант онд 0.004 сая төгрөгийн бараа хүргэлтийн хөлсийг бараа материал дансанд бүртгэснийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны ажиллагсадтай холбоотой авлагын эхний үлдэгдэл 1.3 сая төгрөгийн авлага нь Нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага байсныг буруу бүртгэсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэж заасныг тус тус зөрчиж байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "5.1.2-т заасны дагуу авлагыг үнэн зөв бүртгэх

2. **Зардалтай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд цалингийн зардлаас 1.3 сая төгрөгийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал руу зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж хэвших.

3. **Зардалтай холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас тэмцээний шагнал 0.7 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь МУ-ын ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын "1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчиж байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Тайлант онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журам, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах

4. **Зардалтай холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Тайлант онд ОНӨГ-аас зохих шийдвэргүйгээр урсгал зардлаас 6.0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 1.9 сая төгрөгөөр эд хогшил, нийт 7.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-д "Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна" гэж заасныг зөрчиж байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн дагуу ОНӨГ-т саналаа хүргүүлэн тушаал, шийдвэр гаргуулж үндсэн хөрөнгө худалдаж авах

5. **Төрийн өмчтэй холбоотой асуудал**

5.1. Илрүүлэлт:

Тус цэцэрлэгийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 17.5 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 71.3 сая төгрөг байгаа ба 53.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж шинэчилж бүртгүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

/Э.БАТ-ЭРДЭНЭ/ 2/21

Огноо:

АУДИТОР

/И.ГАНСҮХ/

Огноо:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АХЛАХ АУДИТОР

/М.МӨНХБАЯР/

Огноо:

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН ГЭРЭЭТ АУДИТОР

/Л.ПУНСАЛ-ОРЛОМ/

Огноо:

2022.02.17.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/ д	Хөвсгөл аймгийн Их- Уул сумын Хүүхдийн цэцэрлэг	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		6	11.2	1	0.004	0	0	0	0	5	11.2
		6	11.2	1	0.004	0	0	0	0	5	11.2